

Хэвлэлийн эрх чөлөө ба бодит байдал

Ж.Батбаатар, МУБИС-ийн сэтгүүл зүйн тэнхимийн багш

Ардчилсан нийгмийн оршихуйн баталгаа, гол шалгуур үзүүлэлтийн нэг бол чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөө юм. Тэгвэл хэвлэлийн эрх чөлөө нь өнөөдөр манай нийгэмд нэлээд түгээмэл шинжтэй болоод байгаа шиг хэн нэгэн, хэсэг бүлгийн “захиалга”-т эрх ашиг, уриа тунхаг төдий зүйл, аливаа шударга бус үйлдэл, явдлын халхавч бус билээ.

Хэвлэлийн эрх чөлөөний хэмжүүр бол тухайн хэвлэл хүмүүний заяагдмал, язгуур эрх болох мэдээллийн эрхэд үйлчлэх, тэдний энэхүү эрхийг хамгаалах үндсэн үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэх буюу хараат бус нөхцөлд мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулж чадаж буй эсэх тухай асуудал юм.

Өнгөрсөн 20-иод жилд Монголд чөлөөт хэвлэлийг бий болгох, хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чиглэлээр бид юу хийв, одоо юу хийх ёстой вэ? Өнгөрсөн хугацаанд:

1. Ардчилсан хувьсгалын үр шимээр чөлөөт хэвлэлүүд үүсч, иргэд хэвлэн нийтлэх эрхээ эдэлж, хэвлэлийн цагдан хяналт үгүй болсон байна. Шар, бор янз бүрийн нэр хоч зүүж, ололт, дутагдал аль алиныг нь дагуулсан эдгээр хэвлэл социалист хэв маяг, сэтгэлгээний тогтсон загварыг халж өөрчлөх, мэдээллийн өрсөлдөөнт цоо шинэ орчныг бий болгон, чөлөөт хэвлэлийн үндэс суурийг бүрдүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан билээ.

2. 1998 онд хэвлэлийн эрх чөлөөний хууль батлагдан үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулж улмаар хэвлэл мэдээллийн төр засгаас хараат байх болон төрийн хэвлэлийн монополийг халж, чөлөөт хэвлэлийн хөгжлийн орчныг сайжруулахад чухал алхам болсон юм.

3. 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлсэн нь төрөөс авч хэрэгжүүлсэн хэвлэлийн эрх чөлөөг бататгах ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болов.

4. Хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чиглэлээр олон нийтийн болон төрийн бус байгууллагууд байгуулагдан идэвх чармайлттай ажиллаж, сургалт, судалгаа хийх, дотоод гадаадын төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх зэргээр амжилттай ажиллаж байна.

5. Чөлөөт хэвлэлийн хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр холбогдох байгууллага, мэргэжилтнүүд санаачилгатай ажилласнаар өнгөрсөн жилүүдэд зохих үр дүнд хүрч чаджээ.

Энэ мэт хийсэн ажил, хүрсэн үр дүн байгаа хэдий ч ө нийгэм, олон нийтийн дунд чөлөөт хэвлэл буй эсэхэд эргэлзэх, үл итгэх, нэр хүнд нь унах зэрэг сөрөг үзэгдлийн язгуур үндсийг хайж, алдаа дутагдалдаа дүгнэлт хийн ажиллах шаардлага тулгарч байна. Монголд өнөөдөр аль ч хэвлэл мэдээллийн хэрэгслэл ёс юм шиг хэн нэгний ашиг сонирхолд үйлчилж, тэднээсээ хараат байдалд байх болсон нь нууц биш юм.

Чухамхүү ийм учир шалтгаанаар Монгол дах хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилтийн түвшин, бодит байдлыг тодруулах зорилгоор түүнд нөлөөлж байгаа олон хүчин зүйлийн магадгүй гол нь байж болох нэг тодорхой чиглэлээр судалгаа хийсэн юм.

Манайд хэвлэлийн эрх чөлөө байна уу, мэргэжлийн редакц болон сэтгүүлчид хараат бусаар ажиллаж чадаж байна уу, үүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйл юу байна вэ гэсэн асуултуудад бодитой хариулт олохоор өдөр тутмын болон 7,10 хоног тутмын Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Ардын эрх, Хүмүүс, Сэрүүлэг зэрэг зургаан гол сонинд ажилладаг нийт 51 сэтгүүлчээс авсан асуулга судалгааны дүнгээс үзье.




Энэхүү 4 түвшинт асуултад өгсөн хариултаас харахад манай хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсдын дийлэнх олонхи нь хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн байдлыг дундаас доош буюу тааруу гэж үнэлжээ.



Сэтгүүлчдийн 70% нь өөрийнхөө ажиллаж байгаа сонин хэвлэлийн редакцийг ямар нэгэн хэмжээгээр хараат байдалд ажилладаг гэж үздэг байна.

Таны сэтгүүлчийн үйл ажиллагаанд редакциас цензур тавьдаг уу?



Хэвлэлийн мэргэжлийн үйл ажиллагааны үндсэн цөм нь болох редакцийг судалгаанд хамрагдагсдын бараг 60% нь цагдан хяналт хийдэг гэж үзсэн нь тоогүй үзүүлэлт юм.

Дээрх баримтууд монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний байдал тун тааруу төвшинд байгааг илтгэж байна.

Эдгээрээс гадна сэтгүүлчийн үйл ажиллагаанд тавьж буй цагдан хяналтын 50%-ийг эрхлэгчид, 20 орчим хувийг эзэд, санхүүжүүлэгчид тавьдаг бол сэтгүүлчийн үйл ажиллагаанд гаднаас учруулдаг дарамт шахалтад судалгаанд хамрагдагсдын 62.7% нь хааяа өртдөг, 7.8% байнга өртдөг гэж хариулжээ.

Өнөөгийн хэвлэлийн эрх чөлөөнд харшилж, бие даасан байдлыг нь алдагдуулахад нөлөөлж байгаа гол хүчин зүйлсийг сэтгүүлчдийн мэргэжлийн ёсзүйн гажуудал гэж 34%, хараат байдал гэж 32%, тухайн хэвлэлийн улс төрийн үзэл баримтлал гэж 28% нь үзсэн байна.

Энэхүү судалгааны дүн редакци, сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаагаа ямар нэг байдлаар цагдан хяналтын доор явуулдаг мөн сэтгүүлчдийн мэргэжлийн ёсзүйн доройтол, доголдол чөлөөт хэвлэлийн бие даасан байдлыг алдагдуулахад хамгийн их сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулсан нь анхаарал татаж байна.

Хамгийн ноцтой нь өмнөх нийгмийн үед цензур хаанаас тавигддаг, ямар зорилготой зэргээрээ нийтэд ил тодорхой байсан бол харин өнөөдөр манайд хэвлэлийн цензур сэтгүүл зүйн дотоод тогтолцооноос буюу редакциас тавигдах болсон нь илүү далд, үл анзаарагдам байдалд шилжсэн “аюултай” хэлбэр юм. Чухамдаа энэ нь нэг талаас хэвлэлийг сав л хийвэл шүүхээр дарамтлах замаар эсвэл мөнгө хөрөнгө, эрх мэдэлдээ дулдуйдан эрхшээлдээ байлгахыг санаархагчид нөгөө талаас чөлөөт хэвлэлийн нэр барьж дураар авирлан иргэний эрхэд халдах, хэвлэлийг ашиг хонжоо олох хэрэгслэл, ёс бус “захиалгат үйлчилгээ” мэтээр ойлгогчид, тэдний хэвлэлийн эрх чөлөөг өөрсдийн ашиг сонирхолын зүг залах гэсэн оролдлого, явуулгатай ихээхэн холбоотой.

Учир иймд “өөрийн муугийн шалтгааныг эхлээд бусдаас биш өөрөөсөө хай” гэж эртний сургаал үгэнд байдагчлан алдаанаасаа сургамж авч, хэвлэл мэдээлэл үйл ажиллагааныхаа дотоод зохицуулалтын механизмыг боловсронгуй болгох нь юу юунаас чухал байна. Өөрөөр хэлбэл Монголын сэтгүүлзүй “тоглолтын дүрэм”-ээ илүү тодорхой болгож “тоглогч” /хэвлэл, сэтгүүлч/ бүхэн дүрмээ сахин мөрддөг байх эсэхээс чөлөөт хэвлэлийн ирээдүй, оршихуй хамаарах болоод байна.

Чөлөөт хэвлэл бол биднээс байнгын анхаарал, нягт нямбай ажиллагаа шаардаж байдаг өвөрмөц салбар агаад Монголын сэтгүүлзүй чөлөөт хэвлэл үүсэн хөгжсөн энэ 20-иод жилийн хугацаанд хүрсэн өндөрлөг, ололт, амжилтын зэрэгцээ олон зүйл урсгалаараа, мэргэжлийн нарийн зохицуулалтгүй явж ирсний уршгаар чөлөөт хэвлэлийн хөгжлийн мөн чанар, нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндэд халтай багагүй сөрөг үр дагавар дагуулсныг анзааран үзэж, хэвлэлийн эрх чөлөө ихэд эргэлзээтэй, эмзэг байгаа энэ үед чөлөөт хэвлэлийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдол бүрт мэргэжлийн ёс зүйн хариуцлага тооцдог тогтолцоог бүрдүүлэн ажил хэрэг болгох цаг нэгэнт болжээ.

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизм гэдэгт товчхондоо мэргэжлийн түвшний стандарт шаардлагыг хангахуйц, сайтар боловсруулсан ОНМХ-ийн олон талт ёсзүйн дүрэм, байнгын үйл ажиллагаатай сэтгүүлзүйн ёсзүйн комиссийг багтаан ойлгож болно.

Энэхүү мэргэжлийн ёсзүйн дүрэм, комиссийн үйл ажиллагаагаар зохицуулах тогтолцоо нь чөлөөт хэвлэлийн үйл ажиллагааг хязгаарлах, ямар нэг хаалт боолтод оруулах тухай бус хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн эрхийг хамгаалах, мэргэжлийн шалгуур шаардлагыг өндөрсгөж сэтгүүлзүйг цэвэр тунгалаг байлгах тухай л асуудал юм.

**“XIX зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага
2008.12.08**